



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/46

Шивээговь сум

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, Улсын Онцгой комиссын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/113 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг сумын нийт мал, амьтанд 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх тарилга хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- | | |
|----------------------|--|
| Ажлын хэсгийн дарга: | А.Цэрэндолгор
("Хийморь Алтай групп" ХХК-ийн Малын эмч) |
| Гишүүд: | Д.Сувд-Эрдэнэ
(1 дүгээр багийн Засаг дарга)
С.Отгонбаатар
(2 дугаар багийн Засаг дарга) |

3. Тарилгад хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.
4. Мал эмнэлгийн үйлчилгээний технологийн мөрдөлтөнд хяналт тавьж ажиллахыг сумын Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Г.Дашдэлэг)-т, урьдчилан

сэргийлэх тарилгад малчдыг бүрэн хамруулахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Тарилгыг чанартай, стандартын дагуу хийж дуусгахыг малын эмч (А.Цэрэндолгор)-т даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2022 оны 04-р
сарын 18-ны өдрийн 7746 дугаар
захирамжийн хавсралт-1



ДАРХЛААЖУУЛАЛТАНД ХАМРУУЛАХ МАЛЫН ТОО

№	Сумын нэр	Хамрагдах малын тоо / толгой /		
		Үхэр	Гахай	Бүгд
1	Шивээговь	2255	170	2425